

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	
Хуралдааны товч тэмдэглэл:	1-2
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	3-9
1. Байнгын хорооны даргыг сонгох тухай	3-9

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Өргөдлийн байнгын хорооны
07 дугаар сарын 09-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 24 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 38 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Батцэцэг, Л.Мөнхбаясгалан;
Чөлөөтэй: Х.Баттулга, С.Ганбаатар, Х.Ганхуяг, Ч.Ундрэм;
Эмнэлгийн чөлөөтэй: Р.Эрдэнэбүрэн.

Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга А.Ариунзаяа Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэгийг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлсэн талаар танилцуулав.

Нэр дэвшигчээс болон танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн тавьсан асуултад Байнгын хорооны даргад нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, С.Эрдэнэбат, Ж.Золжаргал, Ж.Галбадрах, Д.Рэгдэл нар үг хэлэв.

Д.Рэгдэл: Өргөдлийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэгийг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 0
Бүгд: 15
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 22 минут үргэлжилж, ирвэл зохих 24 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 70.8 хувийн ирцтэйгээр 12 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Д.РЭГДЭЛ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
11 цаг 38 минут.

**ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Д.Рэгдэл: Шинэ байгуулагдсан Өргөдлийн байнгын хорооны гишүүдийн ирц гүйцсэн байна. Оролцож байгаа гишүүдийнхээ ирцийг танилцуулъя.

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ ирсэн байна. Даваасамбуугийн Ганмаа ирсэн байна. Ганзоригийн Лувсанжамц ирсэн байна. Дүгэрийн Рэгдэл ирсэн. Сүхбаатарын Эрдэнэбат ирсэн байна. Жамбын Батсуурь ирсэн байна. Хажекберийн Жангабыл ирсэн байна. Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн ирсэн байна. Мягмардашийн Сарнай гишүүн ирсэн байна. Жанчивын Галбадрах гишүүн ирсэн байна. Жаргалсайханы Золжаргал гишүүн ирсэн байна. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн байна. Саруулсайханы Цэнгүүн гишүүн ирсэн байна. Ингээд Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Өргөдлийн байнгын хорооны 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1 асуудал хэлэлцэнэ. Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу?

Байхгүй юм байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцье.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх талаар танилцуулгыг хийнэ.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Аюушийн Ариунзаяа гишүүн нэр дэвшигчийг танилцуулна.

А.Ариунзаяа: Өдрийн мэнд хүргэе.

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэгийг дэвшүүлж байна.

Одсүрэнгийн Номинчимэг нь 1998 онд Сүхбаатарын нэрэмжит 2 дугаар дунд сургууль, 2001 онд МУИС-ийн харьяа Монгол-Туркийн хамтарсан Байгалийн ухааны шинэ төрөлжсөн дунд сургууль, 2004 онд Токиогийн Гадаад хэлний их сургууль, 2008 онд Токиогийн их сургуулийг Эрх зүйч мэргэжлээр төгсөж, 2010 онд Токиогийн их сургуульд Харьцуулсан эрх зүйн магистр, 2015 онд Колумбын Хуулийн сургууль Хууль зүйн магистр зэрэг хамгаалсан болно.

Одсүрэнгийн Номинчимэг нь 2010-2011 онд “Мицубиши” корпорац Улаанбаатар салбар Хууль эрх зүй, ашигт малтмалын төсөл хариуцсан ажилтан, 2011-2017 онд Хоган Ловеллс Ахлах ахлах хуульч, 2017-2019 онд Өмгөөллийн “Авинекс Партнерс” нөхөрлөл Үүсгэн байгуулагч гишүүн, 2019-21 онд Өмгөөллийн “Номин энд Адвокатс” нөхөрлөл Үүсгэн байгуулагч, захирал, 2021-22 онд Монгол Улсын Их Хурлын Тамгын газар Тэргүүн дэд дарга, 2022-23 онд Монгол Улсын Их Хурлын даргын зөвлөх, 2023-24 онд Нийслэлийн Засаг даргын орлогчоор ажиллаж байсан туршлагатай. 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэгийн ажлын туршлага, төрийн албанд ажилласан мэдлэг, ур чадварыг нь харгалзан үзсэний үндсэн дээр Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байна.

Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Д.Рэгдэл: Аюушийн Ариунзаяа гишүүнд баярлалаа.

Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх талаар өөр саналтай гишүүн байна уу?

Байхгүй юм байна.

Ингээд Байнгын хорооны даргад нэр дэвшүүлж дууслаа.

Байнгын хорооны даргад нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүд байна уу?

Алга байна.

Үг хэлэх гишүүд байна уу? Асуулт эхлээд асуулт. Асуулт уу? Уучлаарай Батсуурь гишүүн асуулт асууна.

Ж.Батсуурь: Номинчимэг гишүүнийг дэмжиж байна. Өргөдлийн Байнгын хороо гэж энэ чинь өмнө байл уу, байгаагүй билүү? Хэд хэдэн зүйлийг энэ D-Parliamnet-д санал өгөөд байгаа 100 мянга хүрсэн гээд. Энэ өөрөө өргөдөл мөн үү? Энэ асуудал ер нь яадаг юм бол? 100 мянган иргэний гарын үсэг зурчихвал Их Хурал, Байнгын хороогоор хэлэлцэнэ гэсэн байдаг. Тэгэхдээ тэр үзэмжээр яваад байдаг. Заримыг нь хэлэлцээд, заримыг нь хэлэлцдэггүй энэ асуудал байдаг. Энэ одоо манай Байнгын хороонд хамаарах уу гэсэн асуудал.

Дээр нь би орон нутагт дунд шатанд ажиллаж байсны хувьд энэ Өргөдлийн байнгын хороог таныг ийм юмыг цэгцлээсэй л гэж ингэж бодоод байна л даа. Хөдөө орон нутагт төрийн өндөр албан тушаалтнууд явахад ингээд хүмүүс асар их цаасан өргөдөл өгдөг. Ингээд тэр Засгийн газар руу ирээд хуваарилагддаг. Буцаад Засгийн газар нь зүгээр дамжуулаад аймаг руу, аймаг нь ахиад сум руу, тэгээд сум нь баг руу. Ингээд л цаас үйлдвэрлэгдээд л яваад байдаг асуудал шийдэгддэггүй.

Тэгэхлээр энийг манай Байнгын хороо шийдвэрлэхгүй бол энэ бараг манай Монгол Улс байгуулагдсанаас хойш л, дарга нар бий болсноос хойш л өргөдөл өгдөг. Тэгээд тэр өргөдөл явсаар байж байгаад дээрээ ирдэг. Тэр хөөрхий цөөхөн улс төрийн шалтгаантай сонгууль дөхөхөөр ч гэдэг юм уу 1 хүнд гэр өгдөг юм уу, 1 байр өгдөг юм уу жаахан асуудлыг нь шийдээд ёстой 1000-аас хүний ганц гэдэг

шиг. Бусад нь ерөөсөө ингээд л цаас үйлдвэрлэгдээд л ингээд яваад байдаг. Тэгээд энэ асуудлыг л хэдүүлээ энэ Байнгын хороо байхдаа цэгцлэхгүй бол хэдий хэмжээний цаас үйлдвэрлэгддэг юм байгаа юм. Тэрний бараг 50, 60 хувь нь энэ өргөдөл байх магадлалтай. Тэрний шуудангийн зардал тэгээд л эргээд л байдаг. Нэг хүн надад ярьж байсан Мөнххаан сумын хэн билээ дээ золиг чинь Үндсэн хуулийн цэцэд би 31 дэх удаагаа өргөдөл өгч байна гэж байгаа юм. 31 дэх удаагаа. Тэгээд яг л очдог бичиг нь он, сар нь өөрчлөгдөөд л буцаад очдог. Өө золигийн чинь нэрийг мартчихлаа. Тийм, тэгэхлээр тэр ингээд л тэр сум дээр очлоо гэхэд тэр хүн яг л нөгөө асуудаг асуултаа. Хариулт нь байдаггүй. Тэгээд ийм зүйлүүдийг бас хийгээсэй гэж бодож байна. Би бас таныг энэ зүйлийг шинэ шатанд гаргаасай. Энэ бүр бугшмал, хэзээ ч яригддаггүй, тэгсэн мөртөө ийм ингээд далд үйлдвэрлэл, тэгээд бие хуурсан, хөөрхий ядарсан хүмүүсийг тэмээн дээр ямааны гарз, ямаан дээр янгианы гарз гэдэг шиг л тэгээд л үзэг, чернилийн, шуудангийн, сэтгэл, хүслийн л ийм л зүйлүүд болоод байдаг. Энэ дээр бас та ямар бодолтой байдаг юм бол доо гэсэн асуулт асууя.

Д.Рэгдэл: Нэр дэвшигч асуултад хариулъя.

О.Номинчимэг: Байнгын хорооны гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Батсуурь гишүүний асуултад хариулъя. Эхний асуудал яг та нөгөө D-Parliament, d.petition-тэй холбоотой асуудлыг асуулаа. D-Parliament-ыг 2022 онд яг Занданшатар дарга санаачлаад олон нийтэд нээлттэй, ардчилсан, дижитал, илүү бас зөвшилцөж ойлголцдог энэ платформыг, иргэдтэйгээ шууд харилцдаг платформыг парламентад нээж өгөх нь зүйтэй гээд энэ асуудлыг энэ төслийг эхлүүлж ингэж хийж байсан.

Миний бие тэр үед яг Улсын Их Хурлын даргын зөвлөхөөр ажиллаж энэ d.petition-ыг ер нь яаж зөв хийх ёстой юм гэдэг дүрэм, журам, олон улсын улсуудын туршлагыг судалж ажиллаж байсан. Тэгээд энэ асуудлыг одоо яг энэ өнөөдөр бидний баталсан Улсын Их Хурлын тухай хуулиараа Өргөдлийн байнгын хороонд d.petition-ээр ирж байгаа энэ өргөдөл, гомдол, цахим саналуудыг бас хариуцуулж өгч байгаа. Тэгээд эндээ энэ дээр бас Золжаргал гишүүн ч гэсэн бас санаачлаад Инновацын байнгын хороон дээр хамтарсан бас хурлыг хийж байсан. Яаж илүү иргэдэд ээлтэй, ойлгомжтой болох вэ гэдэг асуудлыг өшөө дахиад бас нарийвчилж харах хэрэгтэй байна гээд. Тэгэхээр Өргөдлийн байнгын хороо яг энийг илүү олон нийтэд нээлттэй, оролцоотой, тэгээд үзэмжээр биш яг энийг журмыг нь илүү сайжруулах ер нь олон улсын туршлага дээрээ ч гэсэн энийг илүү парламентын гишүүд нь энэ өгсөн саналуудыг нь спонсорлоод улс Улсын Их Хуралд оруулж ирдэг ч гэдэг юм уу ийм дэгүүд байдаг. Тэгэхээр илүү нарийвчилж ажиллах асуудал энэ Өргөдлийн байнгын хорооны чиг үүрэгт хамрагдаж байгаа гэж харж байгаа. Тэгэхээр энэ дээр та бүхнийхээ саналыг сонсоод хамтарч илүү сайжруулах тал дээр ажиллана.

Хоёрдугаарт таны хэлж байгаа яг зөв. Намайг бас Улсын Их Хурлын гишүүн болсноос хойш ч гэсэн та бүхэнд илүү бас туршлагатай тойргоос сонгогдсон гишүүд маш олон өргөдлүүд ирж байгаа. Тэгээд яг бид нарын хийж байгаа юм бол ерөөсөө зүгээр дамжуулагчийн үүрэг хийж байгаа. Ёстой цааснаас цаас руу, тэгээд нохой сүүлээ, сүүл хонгорцгоо гэдэг шиг ингээд даргаас дарга руу бичиг шилждэг дамжуулалтын систем явсаар байгаад яг энэ хүний асуудал, өргөдөл, гомдол ерөөсөө шийдэгддэггүй. Энийг ирж байгаа өргөдөл, гомдлыг бид нар бас 2 ялгаж салгах хэрэгтэй. Хувь хүний асуудал байна уу, эсвэл яг Улсын Их Хурлын бүрэн эрхийн хүрээнд байдаг хууль тогтоох, хууль засах, эсвэл хянан шалгалт хийж

энэний учрыг ойлгож шийдэл гаргах гэдэг асуудал байна уу гэдгийг ялгах ёстой. Тэгээд яг энэ асуудлууд дээр илүү Өргөдлийн байнгын хороо ажиллаж энийг шийдэл олох ёстойгоор шийдэл олох ёстой. Холбогдох мэдээж мэргэжлийн Байнгын хороодууд байгаа. Байнгын хороодууд дээр энэ асуудлыг дэвшүүлэх бол дэвшүүлэх ёстой. Тэгэхээр энэ асуудал нөгөө үеэс үе, шатаас шат руу, даргаас даргын бичиг рүү шилжих биш ард иргэдийнхээ энэ тулгамдсан асуудлуудыг илүү шийдэлтэй ажиллах ёстой гэдэг энэ хүрээнд энэ Өргөдлийн байнгын хороог дахин сэргээж шинээр байгуулж байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ дээр ч гэсэн бид нар ахиц дэвшил гаргаж ажиллах ёстой гэж харж байгаа. Та бүхний бас оролцоотой санал, хүсэлттэй хамтарч энийгээ бас шийдэхэд.../минут дуусав./

Д.Рэгдэл: Батсуурь гишүүн тодруулна.

Ж.Батсуурь: Тийм, түрүүнд би нөгөө хүний нэр санахгүй байсан И.Очирбат юм байна. Энэ та тэмдэглээд авчхаарай. Бүүр яагаад Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын И.Очирбат гэж хүн байгаа. Энэ өөрөө Үндсэн хуулийн цэцэд өгсөн өргөдлийнхөө дагуу хэзээ ч авч чадахгүй, тэгээд суулт зарладаг, сумынхаа Тамгын газар, аймгийнхаа Тамгын газар тэгээд очсон Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Их Хурлын даргад явуулсан өргөдлүүд нь ирдэггүй гэсэн ийм зүйл байгаа. Тэгэхлээр энэ хүнтэй уулзахад бараг ер нь энэ өргөдлийн хариу очдоггүй энэ том Үндсэн хуулийн цэцийн хүний эрхтэй холбоотой асуудлуудыг нь ерөөсөө хэзээ ч шийдвэрлэдэггүй. Тэгэхлээр би 1 л жишээ хэлж байгаа юм. Ийм мянга мянган жишээ байж байгаа нэгд гэвэл.

Тэгэхлээр би өргөдөл, гомдол 2 өөр асуудал гэж бас бодож байгаа. Өргөдөл хүссэн маягтай, асуудлаа шийдүүлэх маягтай. Гомдол ер нь жоохон хэлмэгдэл тал руугаа явчихдаг. Өмч хувьчлалын асуудлаас авхуулаад л олон жилийн хүний сэтгэл тээсэн гомдол.../минут дуусав./

Д.Рэгдэл: Батсуурь гишүүнд микрофоныг нь өгөөрэй.

Ж.Батсуурь: Тийм тэгээд танд бас итгэж байна. Бас шинэ үеийн энэ платформ дээр ажиллах ийм боломжийг шинэ парламентад оруулж ирж, энэ өргөдөл, гомдлын асуудлуудыг цааснаас цаасанд биш, даргаас доош нь дунд шат руу биш, энийг л цэглэдэг цэглэдэг л болгомоор байна. Тухайн шатанд шийдвэрлэж чадахгүй л гэдгийг нь л хэлчихвэл тэр хүн ахиж үзэг, цаас нийлүүлэхгүй байхгүй юу. Тэгэхгүй ингээд шийдэх гээд ч байгаа юм шиг, шийдэхгүй ч юм шиг, дараа ирэхдээ шийдэх гээд ч байгаа юм шиг, дээд талын дарга нь шийдэх гээд ч байгаа юм шиг ингээд энэ өргөдөл, гомдол харахад, сонсоход их энгийн биш юм шиг мөртөө яг энгийн иргэдийн бүр үйлийг нь бардаг эд чинь энэ шүү.

Тийм учраас би бараг бусад Байнгын хороо гэхээсээ илүү энэ асуудал дээр таныг онцгой анхаарч өгөөрэй л гэж хэлэх гэж байна.

Д.Рэгдэл: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү.

Галбадрах гишүүнээр тасаллаа. Эрдэнэбат гишүүнд микрофоныг нь өгье. Ирцээрээ Лувсанжамц гишүүн үг хэлье.

Г.Лувсанжамц: Өргөдлийн байнгын хорооны гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Байнгын хорооны даргаар нэр дэвшиж байгаа Номинчимэг гишүүнийг дэмжиж байна. Та бүхнийгээ бас дэмжиж саналаа өгөөсэй гэж хүсэж байна. 2, 3 шалтгаан байна. Нэгдүгээрх нь олон улсад ажиллаж байсан ялангуяа хууль, эрх зүйн орчныг зөвхөн Монгол Улс гэлтгүй олон улсын шаардлага болон цаашдаа энэ хууль, эрх зүйн орчин яаж өөрчлөгдөж байгаа вэ, ялангуяа хүний эрхийн мэдрэмжтэй, баримжаатай, бодитой өргөдөл, гомдол, саналыг шийдэж чаддаг энэ тогтолцоог Монгол Улсад бий болгох ёстой. Батсуурь сайд бас сая маш зөв асуулт асууж байсан. Энэ тогтолцоог бий болгохын төлөө бүгдээрээ гар, бие хамтраад нийлээд явахад Номинчимэг гишүүн манлайлаад ажиллах бүрэн боломжтой, чадамжтай, туршлагатай мэргэжлийн хүн гэж үзэж байгаа болохлоор дэмжиж саналаа өгөхийг хүсэж байна.

Д.Рэгдэл: Эрдэнэбат гишүүн үг хэлнэ.

С.Эрдэнэбат: Нэр дэвшигчийг дэмжиж байна. Гэхдээ энэ удаагийн Өргөдлийн байнгын хороо өмнө нь байгуулагдаад 1 удаа татан буугдаад эргээд босож байна. Яах аргагүй бас хэрэгцээтэй төр болон иргэнийг холбож байгаа чухал бас Байнгын хороо.

Гэхдээ энэ тал дээр иргэдийн өргөдөл гаргаад байгаа тэр шалтгаан, мөн чанарыг ингээд судлах нь маш чухал. 1 буруу шийдвэрээс болоод хэчнээн мянган хүн энэ өргөдөл, гомдол чирэгдэл, ийм ойлгомжгүй байдал, хууль, эрх зүйн ойлгомжгүй байдал, албан тушаалтны хүнд суртал энэ олон асуудалтай холбоотойгоор гардаг. Зарим гомдол, саналуудыг манай хууль хүчний байгууллагууд ч гэсэн хаалттай байдлаар ингээд үндсэндээ хэргийн нууц гэдэг ч юм уу ийм байдлаар иргэдийг төөрөгдүүлдэг хаядаг ийм бас байгаа.

Тийм учраас ер нь энэ Их Хуралд гаргаж байгаа өргөдлийн тоогоор аль яам, аль салбар, аль албан тушаалтнууд гараад байна түүнд хариуцлага тооцдог механизмыг маш тодорхой болгох хэрэгтэй. Илээд өнгөрөөд, үүнийг магадалъя гэдэг байдлаар асуудалд хандаж болохгүй. Тийм учраас энэ өргөдлийн асуудал дээр маш сайн бид нар мэргэжлийн хувьд цахимжуулах, техник технологи ашиглах, ямар өргөдлүүд ер нь ирээд байдаг вэ, хэрхэн хаана шийддэг вэ? 1 өргөдөл явсаар байгаад сайдад өгсөн нь явсаар байгаад мэргэжилтнээс дамжаад л тэгээд хаядаг. Энэ өөрөө эргээд иргэн төрдөө итгэх итгэлийг сулруулж байгаа хэлбэр.

Өргөдөл гаргаж чаддаггүй, яах учраа ч мэдэхгүй олон бас асуудал байдаг. Тийм учраас иргэдийн энэ хууль тогтоох процесст оролцуулах энэ процессыг сайжруулах, энэ сая юун дээр харахаар маш олон үндэсний хороод, зөвлөлийг буулгачихлаа л даа. Уул нь энэ чинь өөрөө институт байгууллагуудын төлөөллийг оруулж ирээд төртэй харилцах аягүй том гүүр байсан юм. Тэгээд юмыг нэг талаас нь хараад ингээд манайхан шуурахдаа их амархан. Саяхан хэдхэн сарын өмнө байгуулсан Үндэсний бүсийн хөгжлийн хороо гэдэг юмаа байхгүй болгочихсон. Тэгээд Бүсийн хөгжлийн төв гэхээр баахан гишүүд, баахан сайд нар байдаг. Иргэдээс нь байдаггүй, бизнес эрхлэгчдээс нь байдаггүй иймэрхүү юмыг хүртэл байгуулахаасаа авхуулаад бид нар ийм ойлгомжгүй байж болохгүй.

Тийм учраас Номинчимэг дарга дэмжигдээд яасан тохиолдолд иргэдийн өргөдөл яагаад гарав гэдэг тэр мөн чанарын сайн ойлгож, болж өгвөл энэ институт байгууллагуудаар дамжуулж, үүнд нь анализ хийж, нэг мөр ултай суурьтай шийдэхгүй бол өргөдлийг нь дамжуулсан болоод, хэлчихсэн болоод, сонссон болоод хаях юм бол энэ ерөөсөө явахгүй. Гишүүдийн нэр хүнд хүмүүс ч хандахаа болино. Тийм учраас энэ Өргөдлийн байнгын хороо маш их ачаалалтай ажиллаж магадгүй ирэх жилүүдэд. Тэгэхээр энэ тал дээрээ маш сайн санаачилгатай, шинэ бас гадаад, дотоодын тэр шилдэг туршлага юу байдаг юм тэрүүгээр нь ажиллаарай. Өргөдөл хүлээгээд суухаасаа илүүтэй бас сайн явж ажиллах хэрэгтэй Өргөдлийн байнгын хороодын гишүүд маань. Тодорхой асуудлуудаар салбар салбарынх нь чиглэлээр мэргэшээд тэр өргөдлийг судлах, хариу өгөх, чиглүүлэх, хөөцөлдөх гэдэг юм дээр нь ажиллаарай л гэж хэлмээр байна. Амжилт хүсье.

Д.Рэгдэл: Золжаргал гишүүн үг хэлнэ.

Ж.Золжаргал: Өргөдлийн байнгын хороо сэргээн байгуулагдаж байгаад дотроо их баяртай байгаа. Монгол Улс ардчилсан улс, хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг бүтээж байгаа Улсын Их Хурлын бас гүүр болсон иргэдийг сонсох, шууд идэвхтэй харилцах ийм Байнгын хороо байх ёстой гэж үзэж байна.

D-Parliament дээр гаргасан өргөдөл, гомдлын талаар Номинчимэг гишүүн бид хамтраад хэлэлцүүлэг зохион байгуулсан. Тэр хүрээнд иргэдийн өргөдөлд, нийтийн өргөдөл дээр 33 мянга, 70 мянга, 100 мянга босго хүрээгүй өргөдлүүд хаяглах эзэнгүй хаягддаг зүйл байдаг. Тэгээд 10 мянга, 20 мянга гээд энэ босгыг тогтоож өгөөд 33-даа хүрээгүй боловч харьяалах удирдлага, Засгийн газарт чиглэл өгдөг иймэрхүү байдлаар өөрчлөх санал, зөвлөмжийг бас бичсэн байгаа.

Тэгэхээр энэ дээрээ бид үргэлжлээд ажиллана болов уу гэж найдаж байна. Тэгээд нэр дэвшигч Номинчимэгт амжилт хүсье.

Д.Рэгдэл: Галбадрах гишүүн үг хэлнэ.

Ж.Галбадрах: Номинчимэг гишүүнийг дэмжиж байгаа. Манай жагсаалтаас дэвссэн гишүүн байна. Намын мөрийн хөтөлбөр дээр бид нар бас хамтарч санал солилцоод ингээд явж байсан. Боловсролын салбарыг бас их сайн мэддэг. Тэгээд өөрөө Японд бас мэргэжил эзэмшсэн ийм шударга, аль ч тал дээрээ мэргэжлийн хуульч гэдэг тал нь их энэ албанд их тохирох нь гэж ингэж дэмжиж байна.

Ер нь ирэх жил бас боловсролын жил болж байгаатай холбогдоод манай ажлын хэсэг дээр бас багш нараас, хүмүүсээс маш их санал, хүсэлтүүд ирдэг. Ялангуяа энэ судлаачдаас ирж байгаа. Тэгээд энэ их өргөдөл, гомдол чиглэл рүү нь бүүр цааш нь Байнгын хороонд нь тэр чигт нь ингээд саналыг тавиад явчих хэмжээний ч гэсэн ийм юунууд ирдэг. Мэдээж иргэдээс ирдэг, бид нар иргэдтэйгээ шууд харьцах ийм цонх болж ажиллаж байгаа.

Тэгэхээр энэ чиглэлийн өргөдлөөс гадна тийм судлаачид өөрсдөө юмаа гаргаж ирсэн хүмүүс. Энийг бид нар ийм юун дээр танилцуулмаар байна гээд тэгээд зөвхөн ажлын хэсэг дээр танилцах биш энэ цааш нь өргөн хэмжээнд бид нар хүргэмээр байна гэсэн ийм хүсэлтэй хүмүүс бас байдаг юм байна лээ. Энэ тал дээр бас санаачилгатай, нээлттэй ажиллахыг танаас бас хүсэж байна. Бид нар маш сайн оролцоотой, сая гишүүдийн маань хэлж байгаагаас ч гэсэн бид нар

иргэд дээрээ очиж хүлээгээд суугаад байхад ч ингэж харж ажиллаж ингэж явах тал дээр таныг бас их сайхан санаачилгатай ажлаасай, бид бүхэн ингээд дэмжээд ажиллаад явна. Ингээд танд амжилт хүсье.

Д.Рэгдэл: Би бас энэ Байнгын хорооны гишүүний хувьд 2 үг хэлье.

Өргөдлийн байнгын хороо дахин байгуулж байгаад баяртай байгаа. Энэ их чухал Байнгын хороо. Тэгэхээр бид нарын өнөөдөр баталсан Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулиар Өргөдлийн байнгын хороо өргөдлүүдийг, гишүүдэд ирсэн өргөдлүүдийг холбогдох Байнгын хороодоор нь дамжуулж хэлэлцээд холбогдох дэд хороо ч биш юм уу, холбогдох хороодоор хэлэлцүүлж байгаад тэгээд Өргөдлийн байнгын хороонд шилжүүлж байх юм байна лээ.

Тэрнээс гадна Өргөдлийн байнгын хороонд бас хаягласан өргөдөл нэлээн ирэх байх гэж бодож байна. Би бас өмнөх Өргөдлийн байнгын хороонд өргөдөл өгч үзэж байсан юм. Ер нь хэрэгтэй юм шиг байна лээ. Тэр өргөдлийн мөрөөр Нийслэлийн шүдний төв гэдэг эмнэлэг жижигхэн байранд түрээсээр байсан юм. Тэгээд энд болохгүй байна энэ чинь. Цалингаараа амьдардаг улсууд тэр Шүдний төвд очдог. Тэгээд 1 өргөдөл өгсөн шийдээд бас байр гаргаж өгч байсан юм. Тэгэхээр манай Байнгын хороо ч гэсэн ийм асуудлууд, тэрнээс гадна өөр бусад хувь хүнтэй холбоотой олон асуудал ирэх байх. Тэн дээр манай Байнгын хорооны дарга бид нарыгаа зохион байгуулж, амжилттай сайн ажиллаарай гэж захъя.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдээрэй.

Одсүрэн овогтой Номинчимэгийг Өргөдлийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая.

Дүн 100 хувь, санал хураалт маань 100 хувийн амжилт үзүүллээ.

Ингээд Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх ажлыг, асуудлыг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ганмаа танилцуулна. Хамгийн ойрын.

Хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөлөө. Хүрэлцэн ирсэн гишүүддээ баярлалаа.

12.00 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР

